



## ART public UB 2017 Land Art Mongolia

### *Зорилго*

2010 оноос Land Art Mongolia нь LAM 360° Биеналиар дамжуулан олон тооны уран бүтээлийг толилуулж, Land Art-ын хөгжил болон гүйцэтгэлийг таниулсаар ирсэн билээ. Байгаль, соёл, нийгмийн бодлого зэргийн уялдаа холбоог орон зайн үзэгдэх байдал хэлбэрээр харуулдаг Land Art урсгалыг онцгойлон анхаарснаар, тус урсгалыг бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагаа, харилцаа холбоог ашиглан Монголын нийгмийн бүх давхаргын хүн ард болон байгууллагуудыг нэгтгэж, тэдгээрийн үндэс угсаа, үзэл бодлыг холих замаар нэгтгэснээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөхүүлэн дэмжиж байгаа юм.

Өнгөрсөн 6 жилийн хугацаанд Монголын хөдөө орон нутагт олон газарт нээлттэй орон зайг “тайз” болгосноор энэ улсын орчин үеийн урлагт шинэ хандлага бий болсон. Энэхүү бие даасан, хараат бус туршлагаар туршлагаа зузаатгасан LAM 2017 онд үндсэн үйл ажиллагаагаа Улаанбаатар луу шилжүүлж байна. Манай баг, найз нөхөд, хамтран ажиллагсдын үнэ цэнэтэй мэдлэг туршлага LAM-ыг хотын олон нийтэд хандсан урлагийн хөтөлбөр үүсгэн санаачлахад хүргэлээ.

LAM-ын алсын зорилгын хүрээнд, Art public UB аливаа саад тотгорыг үгүй болгож, олон нийтийн дунд урлагийн тухай яриа хөөрөөг бий болгохоор зорьж байна. Энгийн амьдрал өрнөх нийтийн эзэмшлийн талбай, нээлттэй байгууллага, цэцэрлэгт хүрээлэн шиг орж гарахад хялбар байршилд үзэгч олон хоорондоо харилцаа холбоо үүсгэхийг дэмжих юм.

### *Сэдэв/Асуултууд*

*Олон нийтэд хандсан урлаг гэж юу вэ?*

*Нийтийн эзэмшлийн орон зайг хэн тодорхойлдог вэ?*

*Нийтийн эзэмшлийн орон зай дахь урлагийн ач холбогдол юу вэ?*

*Олон нийтийн хүрээлэлд урлагийг ашиглах нь нийгмийн хөгжлийг урагшлуулахад хэрхэн нөлөөлөх вэ?*

*Нээлттэй орон зай болон хотын нягт шигүү дарамттай амьдралыг хэрхэн шинэ арга замаар сүлэлдүүлэх вэ?*

*Land art Mongolia-ийн тавьж байгаа гол асуудлуудыг олон нийтэд хэрхэн таниулах вэ?*

*Олон нийтийг LAM-ыг нухацтайгаар ойлгож, тогтвортой санаануудад гар бие оролцохыг хэрхэн уриалах вэ?*

### **Хугацаа**

**2017 оны 9 сарын 29 – 10 сарын 6**



Art public UB нь Улаанбаатар хотын өөр өөр газарт зохион байгуулагдах олон нийтэд хандсан урлагийн үйл ажиллагаа, олон улсын бага хурал, үзэсгэлэнгийн нээлт болон видео дэлгэцийн нэвтрүүлэг гэсэн хэд хэдэн олон нийтийг хамарсан үйл ажиллагаанаас бүрдэнэ.

## **Илтгэл/танилцуулга хүлээж авах**

### ***Бидний хайж байгаа зүйл:***

10 сарын 1-ний бүтэн сайн өдрийн бага хуралд тавигдах илтгэлийн төсөл, саналууд:

А) 20 минут юм уу

Б) 7 минут

### **Илтгэл:**

Илтгэлийг Англи хэлээр тавина. (Монгол хэл дээрх шууд орчуулгатай). Видео ашигласан лекц (видео проектор) байвал сайн.

### **Саналууд:**

Дараах зүйлсийг багтаана:

(а) илтгэгчийн хувийн мэдээлэл, түүний мэргэжлийн суурь болон лекцийн туршлага

(б) 200 үгнээс ихгүй санал болгож буй илтгэлийн хураангуйд үзэгчдийн боловсролд үзүүлэх нөлөө, сэдвийн гол санаанууд, Антропоцений газарзүй олон нийтэд хандсан урлаг / Land Art-тай давхцаж буй төлөв.

### **Түлхүүр үгс:**

Антропоцений үнэт зүйл дэх газарзүй болон даяарчлал, хүн төрөлхтөн сүйрэл, дотоодын цагаачлал, эрүүл энх амьдрал ба соёл, олон нийтэд хандсан урлагаар дамжуулан амьдралын утга учрыг /дахин/ холбох. (нэмэлт\*)

### **Нийтлэл:**

Эссе, илтгэл, Урлагийн долоо хоногийн үр дүн болон зургуудыг багтаасан нийтлэлийг 2017 оны 11 сард гаргана.

### **Хамтран ажиллагсад/хөрөнгө оруулагчид:**

Prince Claus Сан

### **Холбоо барих:**

LAM 360°

95502300

[office@landartmongolia.com](mailto:office@landartmongolia.com)

[www.landartmongolia.com](http://www.landartmongolia.com)



## ART public UB 2017

Симпозиум / бага хурал

### Агуулга: Газарзүй ба Антропоцени

Хүмүүнлэгийн ухаанд (даян дэлхийд байр сууриа олсон) “хүний үнэт зүйл”-ийг аливаа соёл, соёл иргэншлүүдийн нийтлэг илэрхийлэгч мөн гэж үздэг. Мөн түүнчлэн олон улсын болон үндэстэн дамнасан урлагийн суурь агуулга, даяарчлагдсан урлагийг тодорхойлох үгэнд тооцдог.

Газарзүйн онцлог улам бүр ач холбогдолтой болж байгаа нь сүүлийн хоёр үе/30 жилийн даяарчлалын үйл явцын дагалдах тодорхойлолт байсаар ирлээ. Эдийн засагч Branko Milanovic хүний төрсөн газар, эсвэл амьдрал нь (тэдний нийгмийн давхарга, үндэс угсаа биш) тухайн хүний насан туршийн олз ашгийг тодорхойлогч гол хүчин зүйл болохыг нотолсон. Үндэстэнд суурилсан улс орнууд газар нутгаа хаалттай хил хязгаартай болгохыг дахин анхаарах болсны гол шалтгаануудын нэг нь энэ юм. Жишээ нь: газар нутгийн буян хишиг цагаачдын урсгалаас болж “бохирдох” ёсгүй гэх мэт.

Монголын газарзүй нь маш нарийн тодорхой ба 700 жилийн тэртээ дэлхийн түүхэн дэх хамгийн том эзэнт гүрэн байсан энэхүү үндэстний онцгой соёлын хөгжилд томоохон нөлөө болж өгсөн. Үлгэр домогт, “нүүдлийн”, “цагаачлалын” болон “морины” соёлыг экологийн хувьд тогтвортой хэмээн өгүүлсэн байдаг ба хэрэгчлэгчдэд суурилсан тогтвортой бус, өөрийгөө сүйрүүлж буй капиталист “хөгжсөн” соёлтой улс орнуудын сонирхлыг ихээхэн татаж байна.

Монголын уран бүтээлчид Монголдоо эн тэнцүү үнэлэгддэг олон урлагийн төрлүүдээс сонгох боломжтой байдаг. Жишээ нь: “үндэсний” урлаг (бөө болон буддын шашны нөлөө бүхий), нийгмийг бодитоор харуулсан уран зураг, баримал, модернист урлаг, орчин үеийн урлагийн олон төрөл (хөдөлгөөнт зураг, инсталляц, концепц, үйл явц, гүйцэтгэлд суурилсан уран бүтээл, лайв арт гэх мэт). Гэсэн хэдий ч, Монголоос гадна эдгээр урлагийн төрлүүд эн тэнцүү байр суурийг эзэлж чаддаггүй учраас бүтээлээ олон улсад гаргаж буй уран бүтээлчид толилуулахдаа нийтэд зохих ёсоор хүлээн зөвшөөрөгдөхийн тулд өөрсдийн “хүний үнэт зүйл”-ийг илүү стратегийн арга барилтай байх ёстой болдог.

“Газарзүй ба орчин үеийн хүмүүнлэгийн ухаан” сэдэвт симпозиум Монголын болон бусад газрын урлаг дахь “хүний үнэт зүйл”-ийг илэрхийлж байгаа байдал мөн эсрэгээрээ “хүний үнэт зүйл” урлагийг хэрхэн илэрхийлж байгааг судлах ба хүний үнэт зүйлийг харуулж буй уран бүтээл нийтэд хүлээн зөвшөөрөгдөхөд газарзүйн байршил хэрхэн нөлөөлж байгааг мөн судална. Энэ бага хурал 2018 оны “Газарзүй ба орчин үеийн хүмүүнлэгийн ухаан” сэдэв дээр зохион байгуулагдах LAM 360° 5 дахь удаагийн биеналлийн сэдвийн хүрээнд байх болно.

Conference abstract | the conference will be moderated by Lewis Biggs

Curator Folkestone Triennial | Chairmen Institute for Public Art HK

Professor College of Fine Arts University Shanghai



**Тайлбар:**

Олон улсаас уригдсан 4-8 илтгэгч (хандивлагч боловсролын байгууллагууд болон үндэсний байгууллагууд замын зардлыг хариуцах эсэхээс хамаарна)

Монголын боловсролын байгууллага/ТББ болон урлагийн байгууллагаас 4-8 илтгэгч

**Бага хурлын хэл:**

Англи хэл. Монгол / англи хэл синхроны орчуулгатай

**Төлөвлөж буй оролцогчид:**

150 орчим

**Техникийн ерөнхий шаардлага:**

Видео проектр, дууны систем, Wifi, бага хэмжээний хоол хүргэлтийн үйлчилгээ

Каталог, танилцуулга болон брошурууд танилцуулах ширээ

**Хамтран ажиллаж буй байгууллагууд:**

Монголын Урлагийн зөвлөл, Гёте Институт, Улаанбаатарын Урлагийн академи, Улаанбаатар Их сургууль, Их Британийн элчин, АНУ-ын элчин сайдын яам, Германы элчин сайдын яам, Konrad-Adenauer Сан, Prince Claus Сан

**Байрших газар:**

Улаанбаатар хот, Чингис зочид буудал

**Үйл ажиллагаа явагдах газрууд:**

Хурлын танхим (баталгаажуулах)

Үндэсний Орчин үеийн урлагийн галерэй

Занабазарын музей

Монголын үндэсний музей

Монголын Урчуудын Эвлэлийн Галерэй

**Холбоо барих:**

(+976) 95502300

[office@landartmongolia.com](mailto:office@landartmongolia.com)

[www.landartmongolia.com](http://www.landartmongolia.com)

## ART public UB 2017

### Хөтөлбөр

үндсэн мэдээлэл/ явагдах газар огноог баталгаажуулах

### 2017 оны 9 сарын 29 – 10 сарын 6

#### 9 сарын 29, Баасан гариг

11:00

22:00

Олон улсын зочид хүрэлцэн ирнэ

Хэвлэлийн бага хурал

Хүлээн авалт

#### 9 сарын 30, Бямба гариг

11:00

11:20 - 12:30

13:30 - 17:00

18:00 - 22:00

Нээлтийн үйл ажиллагаа

Зочдын албан ёсны урилгын үг

Урлагийн тоглолт / дуу хөгжим / мультимедиа танилцуулга

Графити урлагийн семинар

УБ Галерэйн үдэш

#### 10 сарын 1, Ням гариг

10:00 – 17:00

10:30 – 11:00

11:00 – 12:30

12:30 – 13:30

17:00

18:00 – 20:00

Бага хурал

Бүртгэл

Танилцуулга

бага хурал / илтгэгчдийн илтгэл хэлэлцүүлэг (чиглүүлэгч бүхий)

хаалтын үг

Оройн зоог (урилгаар)

#### 10 сарын 2, Даваа гариг

12:00 – 17:00

14:00 – 16:00

17:00

20:00

Графити урлагийн семинар

Уран бүтээлчдийг танилцуулах

нээлтийн видео лонж

Концерт

#### 10 сарын 3, Мягмар гариг

10:00 – 19:00

Хөдөө аялалаар явах

/бүртгэнэ / автобусны суудал тоотой/

#### 10 сарын 4, Лхагва гариг

(ИВА-ийн Удирдах зөвлөлийн хурал)



**10 сарын 5, Пүрэв гариг**

14:00 (...) Уран бүтээлчдийг танилцуулах  
(баталгаажуулах)

**10 сарын 6, Баасан гариг**

16:00 (...) Урлагийн тоглолт  
Хаалтын үйл ажиллагаа болон оройн хоол

20:00 үдэшлэг

**Байрших газар:**

Улаанбаатар хот, Чингис зочид буудал

**Холбоо барих:**

LAM 360°  
(+976) 95502900  
[office@landartmongolia.com](mailto:office@landartmongolia.com)  
[www.landartmongolia.com](http://www.landartmongolia.com)